



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/11-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Сүхбаатар сум  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа  
Утас: 70363040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Батмөнх  
Утас: 70363036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn  
Аудитор: Д.Чулуунцэцэг  
Утас: 70362442 Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Аудитын дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.4.1 Мөнгөн хөрөнгө .....	13
3.4.4 Үндсэн хөрөнгө .....	15
3.4.5 Өр төлбөр.....	16
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо .....	16
3.4.8 Зардлын данс .....	17
4. Аудитын тайлан	
4.1 Ерөнхий зүйл .....	20
4.2 Материаллаг байдал.....	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	23
4.5.1 Завсрын аудитын талаар .....	23
4.6Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	24
5. Аудитын илрүүлэлт	
5.2 Албан шаардлага .....	26
5.3 Зөвлөмж .....	27
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	229

## Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль, орчин аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль, орчин аялал жуулчлалын яам
ГХУССЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
МУЗЗНДНТУ	Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УИХ	Улсын Их Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023 03 25 № МА 2023/11-НА-СТА-ТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сайхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайхан сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сайхан сумын ТТЗ нь 2022 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 2,704,890.3 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,101,902.9 мянган төгрөг бүрдүүлж, төлөвлөгөөг 51.6 хувиар давуулсан биелүүлсэн бөгөөд төсвийн зарлагын гүйцэтгэл 91.7 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 8.3 хувиар хэмнэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тайланд тухайн онд сумын ЕБС, ЭМТ, Соёлын ордон, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагууд нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээс сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Тус сумын Хот тохижилтын газар нь төрийн байгууллага, албан газар гэсэн хуулийн этгээдийн нэртэй, улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн хариуцлагын хэлбэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь холбогдох хууль, эрхийн акттай нийцэхгүй байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*Имяган төгрөгөөр!*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,141,268.0	2,171,594.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	493,951.3	1,878,428.2
33	АВЛАГА	972,075.1	245,732.5
35	БАРАА МАТЕРИАЛ	675,241.6	47,433.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	15,173,229.6	4,501,569.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	15,173,229.6	4,501,569.1
39200	Биет хөрөнгө	14,487,798.3	4,025,138.8
39300	Биет бус хөрөнгө	685,431.2	476,430.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	17,314,497.6	6,673,163.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	523,070.1	10,094.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	523,070.1	10,094.6
41300	Өглөг	523,070.1	10,094.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	16,791,427.5	6,663,068.7
51	Засгийн газрын хувь оролцоо	16,791,427.5	6,663,068.7
51100	Засгийн газрын оруулсан капитал	4,016,431.0	718,195.5
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	4,016,431.0	718,195.5
51200	Хуримтлагдсан үр дүн	2,991,634.1	5,061,701.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,783,362.5	883,171.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	17,314,497.6	6,673,163.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Имянган төгрөгөөр!

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	14,125,376.1	6,695,534.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	621,805.2	3,944,113.4
110	Орлогын албан татвар	279,456.2	2,910,839.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	279,456.2	2,910,839.4
113	Хөрөнгийн албан татвар	54,761.0	681,223.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	287,588.0	352,050.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,152,436.7	1,328,888.6
120	Нийтлэг татварын бус орлого	1,152,436.7	1,328,888.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	12,351,134.2	1,422,532.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	12,849,460.0	3,628,299.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,849,460.0	3,628,299.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,780,726.3	3,609,931.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,333,440.8	707,451.9
2102	Ажил олгогчоос НДШ	700,968.3	87,254.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,209,537.6	1,923,564.9
2104	Хангамж, бараа материалын зардал	193,827.7	52,660.6
2105	Нормативт зардал	636,895.2	1,558.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	189,043.2	43,177.2
2107	Томилолт, зочны зардал	8,873.8	4,101.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	338,919.9	280,942.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,169,219.7	509,219.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,068,733.8	18,367.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,275,916.0	3,067,235.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	232,979.6	13,123,133.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,042,936.5	-10,055,898.3

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Имянган төгрөгөөр!

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	15,083,227.6	15,083,227.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	653,079.4	653,079.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,736,307.0	15,736,307.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	12,184.0	12,184.0
9	Тайлант үеийн үр дүн	1,042,936.5	1,042,936.5
10	2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	16,791,427.5	16,791,427.5
11	2022 оны 1-р сарын 1-ээр үлдэгдэл	16,791,427.5	16,791,427.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-75,473.7	-75,473.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	16,715,953.8	16,715,953.8
19	Тайлант үеийн үр дүн	-10,099,815.8	-10,055,898.3
20	2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	6,619,151.2	6,663,068.7

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Имяган төгрөгөөр!*

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	12,679,862.4	5,672,166.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	621,805.2	3,944,113.4
110	Орлогын албан татвар	279,456.2	2,910,839.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	279,456.2	2,910,839.4
113	Хөрөнгийн албан татвар	54,761.0	681,223.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	287,588.0	352,050.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	266,120.5	103,239.2
1181	Газрын төлбөр	18,154.8	245,010.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	3,312.7	3,800.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	283,978.2	305,520.8
120	Нийтлэг татварын бус орлого	283,978.2	305,520.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,774,079.0	1,422,532.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,806,195.7	3,317,368.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,806,195.7	3,317,368.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,736,305.4	3,294,689.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,336,279.2	707,179.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	700,968.3	87,254.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,136,815.3	1,923,564.9
2104	Хангамж, бараа материалын зардал	169,258.5	53,425.5
2105	Нормативт зардал	694,623.8	1,558.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	195,987.3	41,928.7
2107	Томилолт, зочны зардал	8,873.8	4,101.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	339,814.9	280,819.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	153,684.4	194,855.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,069,890.2	22,679.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	873,666.7	2,354,798.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	529,207.3	970,321.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	529,207.3	970,321.2
2200	Дотоод эх үүсвэрээр	529,207.3	970,321.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-529,207.3	-970,321.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-95,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	95,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	249,459.4	1,384,476.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	244,492.0	493,951.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	493,951.3	1,878,428.2

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Имянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хузь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,170,127.20</b>	<b>3,824,325.90</b>	<b>345,801.30</b>	91.71
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,411,060.60</b>	<b>3,209,054.80</b>	<b>202,005.80</b>	94.08
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,367,311.90</b>	<b>3,190,687.20</b>	<b>176,624.70</b>	94.75
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>792,873.50</b>	<b>707,179.30</b>	<b>85,694.20</b>	89.19
210101	Үндсэн цалин	316,438.30	282,150.60	34,287.70	89.16
210102	Нэмэгдэл	83,139.00	65,351.60	17,787.40	78.61
210104	Урамшуулал	78,397.40	70,130.20	8,267.20	89.45
210105	Гэрээт ажлын хөлс	314,898.80	289,546.90	25,351.90	91.95
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос НДШ</b>	<b>106,066.50</b>	<b>87,254.40</b>	<b>18,812.10</b>	82.26
210201	Тэтгэврийн даатгал	72,177.00	59,150.90	13,026.10	81.95
210202	Тэтгэмжийн даатгал	8,481.30	7,343.90	1,137.40	86.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,785.10	5,682.20	1,102.90	83.75
210204	Ажилгүйдлийн даатгал	1,696.20	1,429.80	266.40	84.29
210205	Эрүүл мэндийн даатгал	16,926.90	13,647.60	3,279.30	80.63
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>1,972,565.60</b>	<b>1,923,564.90</b>	<b>49,000.70</b>	97.52
210301	Гэрэл, цахилгаан	101,256.50	93,216.60	8,039.90	92.06
210302	Түлш, халаалт	1,765,457.40	1,733,534.10	31,923.30	98.19
210303	Цэвэр, бохир ус	105,851.70	96,814.30	9,037.40	91.46
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,543.80</b>	<b>48,673.60</b>	<b>1,870.20</b>	96.30
210401	Бичиг хэрэг	10,437.20	10,184.70	252.50	97.58
210402	Тээвэр, шатахуун	25,288.80	24,903.90	384.90	98.48
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,422.60	5,499.90	922.70	85.63
210404	Ном, хэвлэл	888.60	838.50	50.10	94.36
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	500.00	500.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,006.60	6,746.60	260.00	96.29
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>629.90</b>	<b>58.80</b>	<b>571.10</b>	9.33
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	629.90	58.80	571.10	9.33
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>45,179.10</b>	<b>45,128.60</b>	<b>50.50</b>	99.89
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,370.30	3,319.90	50.40	98.50
210604	Урсгал засвар	41,808.80	41,808.70	0.10	100.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>4,800.50</b>	<b>4,101.80</b>	<b>698.70</b>	85.45
210702	Дотоод албан томилот	4,800.50	4,101.80	698.70	85.45
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>285,708.00</b>	<b>278,419.80</b>	<b>7,288.20</b>	97.45
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	283,678.40	277,286.70	6,391.70	97.75
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	269.10	0.00	269.10	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	776.80	715.60	61.20	92.12
210804	Тээврийн хэрэгслийн татвар	611.00	125.40	485.60	20.52
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	140.80	88.00	52.80	62.50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	120.30	116.00	4.30	96.43

210807	Газрын төлбөр	6.30	6.30	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	8.80	0.00	8.80	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	96.50	81.80	14.70	84.77
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>108,945.00</b>	<b>96,305.60</b>	<b>12,639.40</b>	<b>88.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,295.10	89,376.10	11,919.00	88.23
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,649.90	6,929.50	720.40	90.58
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>43,748.70</b>	<b>18,367.60</b>	<b>25,381.10</b>	<b>41.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>43,748.70</b>	<b>18,367.60</b>	<b>25,381.10</b>	<b>41.98</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,837.70	15,837.60	0.10	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,400.20	0.00	21,400.20	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,510.80	2,530.00	3,980.80	38.86
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>674,066.60</b>	<b>615,271.20</b>	<b>58,795.40</b>	<b>91.28</b>
220001	Барилга байгууламж	584,066.60	526,791.00	57,275.60	90.19
221001	Их засвар	90,000.00	88,480.20	1,519.80	98.31
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>85,000.00</b>	<b>0.00</b>	<b>85,000.00</b>	<b>0.00</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	85,000.00	0.00	85,000.00	0.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,170,127.20</b>	<b>3,914,494.80</b>	<b>255,632.40</b>	<b>93.87</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>4,015,529.30</b>	<b>3,766,764.20</b>	<b>248,765.10</b>	<b>93.80</b>
320001	Орон нутгийн төсвөөс	3,507,136.10	3,258,370.90	248,765.20	92.91
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	508,393.20	508,393.20	0.00	100.00
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>154,597.90</b>	<b>147,730.70</b>	<b>6,867.20</b>	<b>95.56</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	147,730.70	-57,730.70	164.15
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	64,597.90	0.00	64,597.90	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	143,947.30	-143,947.30	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	229,804.50	-229,804.50	0.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЭЛ</b>	<b>253.00</b>	<b>102.00</b>	<b>151.00</b>	<b>40.32</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.00</b>	<b>2.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>132.00</b>	<b>50.00</b>	<b>82.00</b>	<b>37.88</b>
620001	Удирдах ажилтан	8.00	8.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	8.00	14.00	36.36
620004	Гэрээт ажилтан	82.00	14.00	68.00	17.07
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>119.00</b>	<b>50.00</b>	<b>69.00</b>	<b>42.02</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	20.00	28.00	-8.00	140.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	5.00	5.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	86.00	9.00	77.00	10.47
650010	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8.00	8.00	0.00	100.00
650012	Шүүгч, прокурор	0.00	0.00	0.00	0.00
650013	УТҮГ	0.00	0.00	0.00	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>460,334.90</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>108,484.80</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>107,201.80</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,751.70</b>
210401	Бичиг хэрэг	1,136.20
210402	Тээвэр, шатахуун	3,585.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	30.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,500.10</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00
210502	Хоол, хүнс	1,500.10
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>98,549.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	98,145.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	404.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,282.90</b>
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,282.90</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,282.90
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>351,850.20</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>351,850.20</b>
220001	Барилга байгууламж	351,850.20
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>460,334.90</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>460,334.90</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,500.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,794.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	454,015.10
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,025.10
131106	Хаагдсан данс	0.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	0.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сайхан сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Аж үйлдвэр, газар тариалан, мал аж ахуй дэд бүтэц, үндэсний эрүүл хүнс, үйлдвэрлэлтээрээ аймаг болон улсдаа тэргүүлэх, төрийн байгууллагаас иргэддээ үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг ил тод нээлттэй болгох, нутгийн удирдлагын байгууллагын бүтцийг оновчтой зохион байгуулах” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2020-2024, аймгийн болон сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах, үр дүнг тооцож, иргэд олон нийтэд мэдээлэх,
- Гадаад дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, шинэ техник технологийг нутагшуулах;
- Үйлдвэр, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, ажилгүйдлийг бууруулах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 192 дугаар тогтоолоор
- *“Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г тогтоосон гэх мэт.*

ТТЗ-ийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ. Тайлант онд дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Сумын төсөвт байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,685,251.8 мянган төгрөгөөр буюу 61.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	493,951.3	1,878,428.2	1,384,476.9
Авлага	972,075.1	245,732.5	-726,342.6
Бараа материал	675,241.6	47,465.9	-627,775.7
Үндсэн хөрөнгө	15,173,229.5	4,457,619.1	-10,715,610.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>17,314,497.6</b>	<b>6,629,245.8</b>	<b>-10,685,251.8</b>
Өр төлбөр	523,070.1	10,094.6	-512,975.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	16,791,427.5	6,619,245.3	-10,172,182.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>17,314,497.6</b>	<b>6,629,245.8</b>	<b>-10,685,251.8</b>

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд нийт хөрөнгө 10,685,251,8 мянган төгрөгөөр буурсан нь ЕБС, ЭМТ, Соёлын төв, цэцэрлэгийн бараа материал, үндсэн хөрөнгө болон 2016 оноос хойш үүссэн түлш халаалтын үнийн зөрүүгийн өглөг зэргийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох яамдад үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байгаа бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,878,428.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 1,384,476.9 мянган төгрөгөөр буюу 3.8 дахин өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	493,951.3	1,878,428.2	1,384,476.9
Төгрөг	493,951.3	1,878,428.2	1,384,476.9
Төрийн сангийн харилцах	493,951.3	1,878,428.2	1,384,476.9
<b>Дүн</b>	<b>493,951.3</b>	<b>1,878,428.2</b>	<b>1,384,476.9</b>

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын дансны 1,647,061.3 мянган төгрөг, ОНХС-ийн дансны 7,275.6 мянган төгрөг, хоршоог

хөгжүүлэх сангийн 222,528.8 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансны 1,562.5 мянган төгрөг тус тус байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 245,732.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 726,342.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Татаас, санхүүжилтийн авлага	577,055.2		-577,055.2
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,874.7		-2,874.7
Зээлийн авлага /ХХС/	385,379.5	239,665.9	-145,713.6
Хувь хүмүүсээс авах авлага	6,765.6	6,066.7	-698.9
<b>Дүн</b>	<b>972,075.1</b>	<b>245,732.5</b>	<b>-726,342.6</b>

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын эцсийн үлдэгдлийн 97.5 хувь буюу 239,665.9 мянган төгрөгийг хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлага эзэлж байгаа бөгөөд тухайн онд шинээр зээл олгоогүй байна.

### 3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 47,465.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 627,775.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	47,946.6		-47,946.6
Эм боох материал	87,578.2		-87,578.2
Бичиг хэргийн материал	13,163.6	1,426.3	-11,737.3
Аж ахуйн материал	306,915.4	43,062.9	-263,852.5
Сэлбэг хэрэгсэл	2,623.3	730.0	-1,893.3
Түлш, шатах тослох материал	1,927.1		-1,927.1
Барилгын засварын материал	9,443.2		-9,443.2
Хүнсний материал	19,677.1		-19,677.1
Бусад хангамжийн материал	185,868.1	2,246.6	-183,621.5
<b>Дүн</b>	<b>675,241.6</b>	<b>47,465.9</b>	<b>-627,775.7</b>

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн бараа материалын дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 627,775.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 98,149.2 мянган төгрөгийн материал худалдан авч, 101,125.4 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулан, 624,799.5 мянган төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох яамдын төсвийн ерөнхийлөн захирагчид үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

### **Аудитын илрүүлэлт:**

#### **Хот тохижилтын газар:**

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр Хот тохижилтын газар нь 12,373.8 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй байна.
- Тайлант онд худалдан авсан 1,896.3 мянган төгрөгийн барилгын засварын материалыг аж ахуйн материалын дансанд бүртгэж тайлагнасан,

### **3.4.4 Үндсэн хөрөнгө**

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,784,189.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 13,536,079.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	12,968,289.8	1,303,812.0	-11,664,477.8
Авто-тээврийн хэрэгсэл	397,155.3	146,475.0	-145,680.3
Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,762,919.8	149,296.6	-1,912,216.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	620,039.9	69,149.9	-550,890.0
Зам, гүүрний байгууламж	20,381.3	153,987.5	-133606.2
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	59,500.0	59,500.0	-
Бусад үндсэн хөрөнгө	2,791,651.2	3,422,723.9	631,072.7
Ном	4,780.5	-	-4,780.5
Программ хангамж	29,978.7	2,930.8	-27,047.9
Бусад биет бус хөрөнгө	665,582.1	476,313.1	-189,269.0
<b>Дүн</b>	<b>19,320,268.7</b>	<b>5,784,189.0</b>	<b>-13,536,079.7</b>

/мянган төгрөгөөр/

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

ТТЗ-ийн үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 13,536,079.7 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 91,680.0 мянган төгрөгийн /төсвийн хөрөнгө оруулалтаар ЗДТГ-т 88,480.1 мянган төгрөгийн нийтийн эзэмшлийн төв талбайн шинээр засварласан, Захирагчийн албанд 3,199.9 мянган төгрөгөөр шинээр компьютер/ хөрөнгө худалдан авсан, ОНХС-аас 1,120,323.9 мянган төгрөгийн /Хот тохижилтын газарт 1,025,847.3 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг, камер, бичил хорооллын дундах авто зогсоол, зам талбай, Номгон тосгоны Захирагчийн албанд 94,476.6 мянган төгрөгийн гэрэлтүүлэг/-ийг, аймгийн ХАА-н газраас ЗДТГ-т 2,857.6 мянган төгрөгийн хүлэмжийг тус тус шилжүүлэн авсан болон 14,697,464.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох ерөнхийлөн захирагчдад шилжүүлэн, сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 45, 47 дугаар тогтоолоор /ИТХ 1,686.8 мянган төгрөгийн, ЗДТГ 48,296.2 мянган төгрөгийн, Захирагчийн алба-3,493.8 мянган төгрөгийн/ нийт 53,476.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан зэргээс шалтгаалсан байна.

### **Аудитын илрүүлэлт:**

- ИТХ нь 899.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоогүйгээс элэгдэл байгуулаагүй,

**Хот тохижилтын газар:**

- Хот тохижилтын газар нь 77,500.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоогүйгээс элэгдэл байгуулаагүй,
- Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын чанартай 59,500 мянган төгрөгийн бурхан, зулын цөгц зэргийг бүртгэсэн,
- Өмч хөрөнгийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих зорилго бүхий Өмч хамгаалах зөвлөлийг байгуулаагүй,
- Байгууллагын нярав, нягтлан бодогчид солигдох үед эд хөрөнгийн тооллого хийж тооцоог бодож, үлдэгдлийг баталгаажуулаагүй,

**3.4.5 Өр төлбөр**

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 10,094.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 512,975.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
			Өсөлт (+), Бууралт (-)	
Хувь хүмүүст төлөх өглөг	1,610.2	0	-1,610.2	
Байгууллагад төлөх өглөг	521,459.9	9,822.1	-511,637.8	
Ажилчидтай холбогдсон өглөг		272.5	272.5	
<b>Дүн</b>	<b>523,070.1</b>	<b>10,094.6</b>	<b>512,975.5</b>	

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэлд ИТХ-ын ХХОАТ-ын 272,5 мянган төгрөг, ерөнхий орлогын данснаас олгох 1,582.3 мянган төгрөг, барьцаа хөрөнгийн дансны 1,562.5 мянган төгрөг, Биеийн тамир, спортын хорооны түлш халаалтын зардлын 6,677.3 мянган төгрөгийн өглөг тайлагнагдсан байна.

Өр төлбөр данс 512,975.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөр халаалтын үнийн зөрүүгээс үүссэн он дамжсан 512,975.5 мянган төгрөгийн түлш халаалтын өглөгийг холбогдох ерөнхийлөн захирагчдад шилжүүлсэнтэй холбоотой байна.

**Аудитын илрүүлэлт:**

- ИТХ нь төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог тухай бүр хянаагүйгээс ХХОАТ-т **272.5** мянган төгрөгийн өглөг үүсгэсэн,

**3.4.6 Засгийн газрын хувь оролцоо**

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 6,619,151.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 10,172,276.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,016,430.9	718,195.5	-3,298,235.4
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>2,991,634.1</b>	<b>5,017,784.1</b>	<b>2,026,150.0</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,783,362.5	883,171.7	-8,900,190.8
<b>Дүн</b>	<b>16,791,427.5</b>	<b>6,619,151.2</b>	<b>-10,172,276.3</b>

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 10,172,276.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурснаас шалтгаалсан байна.

### 3.4.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **45,158.4** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

- Төсвийг зохистой удирдаагүйгээс ИТХ 450.0 мянган төгрөг, ЗДТГ 1,484.5 мянган төгрөг зэрэг нийт **1,934.5** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ЗДТГ 1,376.0 мянган төгрөг, Хот тохижилтын газар 7,950.0 мянган төгрөг зэрэг нийт **9,326.0** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан,
- ИТХ, ЗДТГ нь төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр үнэлж, үр дүнгийн урамшуулал олгоогүй,

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 34 дүгээр “Сайхан сумын 2022 оны төсөв тодотгон батлах” тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,272,044.3 мянган төгрөгөөр бууруулан 2,704,890.3 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 4,101,902.9 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 51.6 хувиар давуулсан биелүүлсэн байна.

Хүснэгт 8. Төсвийн орлогын гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>2,704,890.30</b>	<b>4,101,902.90</b>	<b>1,397,012.60</b>	<b>151.6</b>
Орлогын албан татвар	2,564,890.30	3,944,113.20	1,379,222.90	153.8
Хувь хүний орлогын албан татвар	1,851,000.00	2,705,968.20	854,968.20	146.2
Үйл ажиллагааны орлого	51,000.00	58,636.40	7,636.40	115.0

Цалин хөлс, шагнал, урамшуулал болон хөдөлмөр эрхлэлтийн орлого	1,800,000.00	2,647,331.80	847,331.80	147.1
<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>487,600.00</b>	<b>799,660.70</b>	<b>312,060.70</b>	<b>164.0</b>
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	340,000.00	593,303.60	<b>253,303.60</b>	174.5
Хөрөнгийн орлого	74,000.00	137,720.60	63,720.60	186.1
Хөрөнгө борлуулсны орлого	71,500.00	67,150.50	-4,349.50	93.9
Бууны албан татвар	2,100.00	1,486.00	-614.00	70.8
<b>Малд ногдуулах албан татвар</b>	<b>50,000.00</b>	<b>86,434.00</b>	<b>36,434.00</b>	<b>172.9</b>
<b>Бусад нийтлэг Төлбөр, хураамж</b>	<b>114,000.00</b>	<b>103,239.10</b>	<b>-10,760.90</b>	<b>90.6</b>
Улсын тэмдэгтийн хураамж	50,000.00	43,181.70	-6,818.30	86.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	0	25,103.80	25,103.80	
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	64,000.00	34,953.60	-29,046.40	54.6
<b>Газрын төлбөр</b>	<b>62,150.30</b>	<b>47,181.70</b>	<b>-14,968.60</b>	<b>75.9</b>
<b>Газрын дуудлага худалдаа</b>	<b>0</b>	<b>197,255.90</b>	<b>197,255.90</b>	
<b>Төлбөр, хураамж</b>	<b>140</b>	<b>3800.9</b>	<b>3,660.90</b>	<b>2714.9</b>
Ойн нөөц ашигласны төлбөр	0	348.6	348.60	
Ус рашаан ашигласны төлбөр	0	54.7	54.70	
Ан амттаны нөөц ашигласны төлбөр	50.0	0	-50.00	
Байгалийн ургамлын нөөцийн төлбөр	90.0	3,397.60	3,307.60	3775.1
<b>Татварын бус орлого</b>	<b>140,000.00</b>	<b>157,790.00</b>	<b>17,790.00</b>	<b>112.7</b>
Торгуулийн орлого	120,000.00	134,109.90	14,109.90	111.8
Бусад орлого	20,000.00	23,680.10	3,680.10	118.4

Эх сурвалж: Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан.

### Давж биелсэн орлогын талаар:

Цемент Шохой ТӨХК-ийн цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотой цалин, хөлс, шагнал, урамшуулал тэдгээртэй адилтгах орлого 847,331.8 мянган төгрөгөөр, бүртгэлгүй байсан хөрөнгийг шинээр бүртгэн татварын ногдол үүсгэн орлого төвлөрүүлснээс үл хөдлөх хөрөнгийн албан татвар 253,303.6 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Тайлант онд газрыг эргэлтэд оруулах бодлого боловсруулан, ашиглах боломжтой газрыг дуудлага худалдаа зохион байгуулан олгосноор газрын дуудлага худалдааны орлого 197,255.9 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

### Тасарсан орлогын талаар:

Сумын ИТХ-аас айл өрх, ААНБ-аас хураах хог хаягдлын хураамжийн үнийг нэмэгдүүлсэн тогтоол шийдвэр эцэслэн гараагүй байхад орлогын төлөвлөгөөг 30,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн баталснаас төлөвлөгөөг 29,046.4 мянган төгрөгөөр тасалсан байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 5,859,309.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 3,976,934.6 мянган төгрөг, ерөнхий орлогын оны эхний үлдэгдлээс 275,484.8 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 64,597.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг 508,393.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 90,000.0 мянган төгрөг зэрэг нийт 4,915,410.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, аймгийн төсөвт 576,557.3 мянган төгрөгийг төвлөрүүлэн, нийт зардалд **4,338,853.2** мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 1,272,044.3 мянган төгрөгөөр бууруулан **2,704,890.3** мянган төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх 576,557.3 мянган төгрөгийг цуцалж, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг **453,804.3** мянган төгрөгөөр, оны эхний үлдэгдлээс санхүүжих дүнг 72,956.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж **348,441.5** мянган төгрөгөөр, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс **64,597.9** мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг **508,393.2** мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс **90,000.0** мянган төгрөгийн зэрэг нийт **4,170,127.1** мянган төгрөгийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлж, зарцуулахаар эцэслэн баталсан байна.

### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн тодотголоор төсвийн орлого, зарлагыг 168,726.1 мянган төгрөгөөр бууруулж **4,170,127.1** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөр, 29 арга хэмжээг санхүүжүүлэхээр сумын төсвийн орлогоос 2,704,890.3 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр 453,804.3 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгээр 508,393.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 90,000.0 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 348,441.5 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 64,597.9 мянган төгрөг зэрэг нийт **4,170,127.1** мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгаас авах санхүүгийн дэмжлэгээр 453,804.3 мянган төгрөг, орон нутгийн төсвийн орлогоос 4,101,902.9 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 508,393.2 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 147,730.7 мянган төгрөг, сумын төсвийн урьд оны үлдэгдлээс 348,441.5 мянган төгрөг, ОНХС-ийн оны эхний үлдэгдлээс 64,597.9 мянган төгрөг зэрэг нийт **5,624,870.5** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **3,824,325.9** мянган төгрөг буюу 91.7 хувьтай тайлагнагдсан нь СХС-аас төлөвлөсөн хэмжээгээр зээл олгоогүй, ТЗШ-д орон нутгийн төсвөөс олгох тогтмол зардлыг гүйцэтгэлээр санхүүжүүлсэн, харьяа байгууллагуудын төсвийн хэмнэлт зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчос төлөх НДШ-ийн зардал 104,506.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 49,000.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 1870.1 мянган төгрөгөөр, норматив зардал 571,1

мянган төгрөг, Эд хогшил урсгал засварын зардал 50,4 мянган төгрөг, томилолтын зардал 698,7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 7288.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 12,639.4 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардал 25,381.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчдаас эрх нь шилжсэн аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтын 446,978.2 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 12,831.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 525.0 мянган төгрөг зэрэг нийт **460,334.9** мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 4,751.7 мянган төгрөг, нормативт зардалд 1,500.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2,400.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал /замын сан/ 98,549.9 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 351,850.3 мянган төгрөг зэрэг нийт 459,052.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,282.9 мянган төгрөгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан ТТЗ-ийн сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Хот тохижилтын газрын нэр, хариуцлагын хэлбэрийг өөрчлөх, үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох, үндсэн хөрөнгө, бараа материалыг зөв ангилж бүртгэх, өмч хамгаалах зөвлөлийг байгуулах, албан хаагчдын улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тогтмол олгож байх зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Чулуунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/43 дугаар албан бичгээр ирүүлсэн байн

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 12,849,460.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **128,494.6** мянган төгрөгөөр тооцсоныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, ЭМТ, Соёлын ордон, Соёлын төв, цэцэрлэг зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан нь тус тусын яаманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 3,628,266.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **36,282.6** мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэлийг хүргүүлсэн байна.

Үүнээс Сайхан сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- *Байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг хэмнэх зорилгоор цахилгааны тоолуурыг шинэчилсэн,*
- *Албан томилолт, тээвэр шатахуун, бараа үйлчилгээний бусад зардлыг хэмнэх зорилгоор ажилтнуудын сургалт, уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан,*
- *Бичиг хэргийн зардлыг хэмнэх зорилгоор дотоод сүлжээ ашиглаж баримт бичгийг боловсруулсан,*

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 104,506.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 49,000.7 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 1870.1 мянган төгрөгөөр, норматив зардал 571,1 мянган төгрөг, Эд хогшил урсгал засварын зардал 50,4 мянган төгрөг, томилолтын зардал 698,7 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ 7288.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 12,639.4 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 25,381.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэж, нийт зардлыг 345,801.2 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар хэмнэсэн байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	ТТЗ	155	153	1	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	151	150	1	-
3	Засаг даргын Тамгын газар	151	151	1	-
4	Тосгоны захирагчийн алба	151	150	1	-
	<b>Нийт дүн</b>	<b>608</b>	<b>604</b>	<b>4</b>	

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 608 мэдээллээс 604 мэдээллийг хугацаанд нь, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

*Илрүүлэлт:* Хот тохижилтын газар нь төрийн байгууллага, албан газар гэсэн хуулийн этгээдийн нэртэй улсын төсөвт үйлдвэрийн газар гэсэн хариуцлагын хэлбэртэйгээр айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог тээвэр, гудамжны гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллага нь 2022 онд орон нутгийн төсвийн хог хаягдлын хураамжийн орлогод 34,953.60 мянган төгрөг төвлөрүүлж, орон нутгийн төсвөөс 220,588.6 мянган төгрөгийн санхүүжилт авч эх үүсвэр бүрдүүлэн, зарцуулсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн “Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилал”-ын 15.3-т “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ” гэж заасан байдаг бөгөөд Хот тохижилтын газар нь зөвхөн төрийн хэрэгцээнд зориулан үйл ажиллагаа явуулдаг бус иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа эрхэлж байгаа нь улсын төсөвт үйлдвэрийн газрын тодорхойлолтыг хангахгүй байна.

Зөвлөмж: Цаашид тус газрын статус, хариуцлагын хэлбэрийг холбогдох хууль, эрхийн актад нийцүүлэн зохион байгуулах зөвлөмж өгөв.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулсан.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 517,554.2 мянган төгрөгийн 21 зөрчил илрүүлж, 6,078.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 122,173.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 14, хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлж, 389,302.9 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Үүнээс бараа материалын худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, төсвийг бодит тооцоо судалгаа, мэдээлэл дээр үндэслэн төлөвлөж, зарцуулаагүй гэсэн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Хүснэгт 9 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хариуцлага тооцуулах	1		1		
Акт	2	6,078.0	2	6,078.0	100.0
Албан шаардлага	14	122,173.3	14	122,173.3	100.0
Зөвлөмж	4	389,302.9	2	389,302.9	50.0
<b>Нийт дүн</b>	<b>21</b>	<b>517,554.2</b>	<b>19</b>	<b>517,554.2</b>	<b>90.5</b>

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх, төсвийг бодит тооцоо судалгаа, мэдээлэл дээр үндэслэн төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулах гэсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг шалгаж амжаагүй тул Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн сэдэвт аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

2. Тус сумын батлагдсан төсөвтэй холбоотой дараах асуудлуудыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Сумын ИТХ-ын төсөвт үндсэн чиг үүрэгт хамааралгүй Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 4,000.0 мянган төгрөгийн төсөв баталсан байгаа нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3<sup>1</sup>, 46.6<sup>2</sup> дахь заалт болон Хууль зүйн сайд, Сангийн сайдын 1998 оны 88/152 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам”-ын 1.5<sup>3</sup>, 2.7<sup>4</sup> дахь заалтуудтай нийцэхгүй байна. Сумын ИТХ нь дээрх асуудалтай холбоотой бодлогыг тодорхойлж, тухайн арга хэмжээний зарцуулалтад хяналт тавих чиг үүрэгтэй байгууллага юм. Иймд цаашид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төсвийг холбогдох төсөвт нь тусгаж, батлах нь зүйтэй байна.

3. Засаг даргын орлогчоор ажиллаж байсан Б.Үүрдмөнхөд сонгуулийн үр дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн гэж **5,340.1** мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгох Засаг даргын 2022 оны Б/22 дугаар захирамжийн хууль, эрх зүйн актыг буруу сонгож хэрэглэсэн байна. Өөрөөр хэлбэл Хөдөлмөрийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, 82.3 дугаар зүйлийг бус Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний

<sup>1</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна.

<sup>2</sup> Зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хөрөнгийг зөрчлийн нөхцөл байдал, цаашдын төлөв байдлыг харгалзан асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тухай бүр тусгаж, зарцуулна.

<sup>3</sup> Батлагдсан хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төсвөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан сум, дүүргийн төсөвт олгосон хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн нэрээр тусгай дансанд төвлөрүүлнэ.

<sup>4</sup> Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна.

удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно” гэсэн заалтыг үндэслэсэн байна. Цаашид захирамжийн хууль, эрх зүйн үндэслэлийг зөв сонгож хэрэглэх нь зүйтэй юм.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар ЗДТГ нь ХХААХҮЯ-аас шилжүүлэн авсан **43,950.0** мянган төгрөгийн 8 ширхэг хүлэмжийг үндсэн хөрөнгөд бүртгэж тайлагнаагүй алдааг залрууллаа.

ТТЗ-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт **147,210.5** мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа<sup>5</sup> илэрлээ. Үүнд:

### ИТХ:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 899.1 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоогүйгээс элэгдэл байгуулаагүй, тайлант үеийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан,
- Тайлант онд худалдан авсан 7,415.1 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар тайлагнасан,

### Хот тохижилтын газар:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 77,500.0 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглалтын жилийг тооцоогүйгээс элэгдэл байгуулаагүй тайлант үеийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан,
- Үндсэн хөрөнгийн дансанд бараа материалын чанартай 59,500 мянган төгрөгийн хатгамал, наамал, шаазан, зэс, шавар бурхад, зулын цөгц зэргийг бүртгэсэн,
- Тайлант онд худалдан авсан 1,896.3 мянган төгрөгийн барилгын засварын материалыг аж ахуйн материалын дансанд ангилал буруу бүртгэж тайлагнасан,

Эдгээр нь Нягтлан бодлох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын “Үндсэн хөрөнгийн элэгдлийн бүртгэл”-ийн 4.16, 4.30, 4.35 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Дээрх алдаануудыг 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийж, санхүүгийн тайланг үнэн зөв илэрхийлэх зөвлөмж өгөв.

<sup>5</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт **24,582.2** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **15,256.2** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, **9,326.0** мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

## 5.1 Албан шаардлага

### ИТХ :

1. Төсвийг зохистой удирдаж, төлбөр тооцоог тухай бүр хянаагүйгээс ХХОАТ-т **272.5** мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж өр төлбөр үүсгэлгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

2. Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлын батлагдсан төсвөөс иргэдийн төлөөлөгч болон өөр байгууллагын албан хаагчдад 400.0 мянган төгрөгийг тэтгэмж урамшуулал, бичиг хэргийн зардлын батлагдсан төсвөөс бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардалд 1,934.5 мянган төгрөг, нийт 2,334.5 мянган төгрөгийг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Үүнд:

- ИТХ-ын төсвөөс сумын иргэдийн төлөөлөгчид 300.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардалд 450.0 мянган төгрөг,
- ЗДТГ-ын төсвөөс улсын төсвийн байгууллага болох Улсын бүртгэлийн газрын улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивчид /Б.Уянга хүүхдийн сэвлэг үргээх ёслолд/ 100.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн арга хэмжээний зардалд 1,484.5 мянган төгрөг,

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын Бичиг хэрэг: “Бичгийн болон тооцоолон бодох, хэвлэх, олшруулах **техник хэрэгсэлд шаардагдах хор, цаас, ... хэвлэмэл хуудас...** тэдгээртэй адилтгах хэрэгслийн зардал багтана”, Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшил: “Байгууллагын дотоод журамд заасны дагуу **албан хаагчид голдуу хагас болон бүтэн жилийн эцэст нэг удаа олгох** мөнгөн шагнал, урамшуулал, эсхүл журамд заасан нөхцөлөөр олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмжийн зардал энд хамаарна” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэв.

### **ЗДТГ:**

**3.** Сумын Засаг даргын орлогч О.Аюушбаатарын ээлжийн амралтыг биеэр бүрэн эдлүүлээгүйгээс 5 хоногийн **275.4** мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчийг биеэр нөхөн амруулж, цалингийн давхардал үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### **Хот тохижилтын газар:**

**4.** Өмнөх онд өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 12,373.8 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэн, бүртгэж байх албан шаардлага хүргүүлэв.

**5.** Байгууллагын нярав, нягтлан бодогч нар солигдох үед эд хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.2: “Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Эд хөрөнгө хариуцагч нар солигдох үед хөрөнгийн тооллого хийх, тооцоо бодож баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэх.

### **5.2 Зөвлөмж**

1.1 Илрүүлэлт: ЗДТГ нь төрийн албан хаагчдын ажлын үр дүнг улирал бүр үнэлж, үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгоогүй байгаа нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн

урамшуулал олгох журмын 1.3-д “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**1.2 Зөвлөмж:** Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг улирал бүр үнэлэн, үр дүнгийн мөнгөн урамшуулал олгож байх.

**2.1 Илрүүлэлт:** Өмч хамгаалах зөвлөлөөр автомашинд засвар, үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх техникийн комиссын акт, дүгнэлт гаргалгүйгээр ЗДТГ 1,376.0 мянган төгрөг, Хот тохижилтын газар 7,950.0 мянган төгрөг, нийт **9,326.0** мянган төгрөгийн засвар, үйлчилгээг гүйцэтгэж бүртгэл, тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд үнэн зөв тусгаж байх.

#### **Хот тохижилтын газар:**

**3.1 Илрүүлэлт:** Байгууллагын өмч хөрөнгийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ашиглалтад хяналт тавих зорилго бүхий Өмч хамгаалах зөвлөлийг байгуулаагүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31,4-т “... өмч хамгаалах байнгын зөвлөлийг үндсэн үйлдвэрлэл хариуцсан дэд захирал, эсхүл түүний үүрэг биелүүлдэг менежерээр толгойлуулж ерөнхий нягтлан бодогч, технологич зэрэг мэргэжлийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр захирлын шийдвэрээр байгуулна”, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам” батлах тухай тогтоолын 2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Өмч хамгаалах зөвлөл байгуулж ажиллахыг төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад даалгасугай” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

**3.2 Зөвлөмж:** Өмч хамгаалах зөвлөлийг дээрх хууль, журмын дагуу байгуулж өмч хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ИТХ	2	8,314.2	1	899.1	1	7,415.1			2	8,314.2	2	8,314.2
ЗДТГ	1	43,950.0	1	43,950.0			1	43,950.0				
Хот тохижилтын газар	3	138,896.3	2	137,000.0	1	1,896.3			3	138,896.3	3	138,896.3
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>191,160.5</b>	<b>4</b>	<b>137,899.1</b>	<b>2</b>	<b>9,311.4</b>	<b>1</b>	<b>43,950.0</b>	<b>5</b>	<b>147,210.5</b>	<b>5</b>	<b>147,210.5</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ИТХ	3	1,022.5			3	1,022.5						
ЗДТГ	5	3,235.9			3	1,859.9	2	1,376.0				
Хот тохижилтын газар	4	20,323.8			2	12,373.8	2	7,950.0				
<b>Дүн</b>	<b>12</b>	<b>24,582.2</b>			<b>8</b>	<b>15,256.2</b>	<b>4</b>	<b>9,326.0</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>	<b>1</b>						<b>1</b>	
<b>Нийт дүн</b>	<b>13</b>	<b>24,581.8</b>			<b>8</b>	<b>15,255.8</b>	<b>5</b>	<b>9,326.0</b>